

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийсэн төсвийн тодруулгын тайлан	22
5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН
ЗАХИРАЛ Д.СҮРЭНЧИМЭГ ТАНАА

2019.02.28 № 06/355
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирал Д.Сүрэнчимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хуулийн дагуу үнэн зөв тооцох, нийгмийн даатгалын шитмгэлийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 09-нөөс 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Мэдээлэл-Аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Д.Туяа анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлж, багийн ахлагч Н.Ганданбаавар, аудитор Э.Отгонзаяа, шинжээч С.Наранцэцэг нар аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааг боловсролын хөгжлийн бодлого болон нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан орчин үеийн мэдээлэл харилцааны технологид суурилж олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулж, хүний хөгжлийг дээдлэн боловсон хүчний мэдлэг, чадварыг тасралтгүй дээшлүүлж, чадварлаг, ёс зүйтэй хамт олныг бүрдүүлэн салбарынхаа тэргүүлэгч байгууллага болно гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- СӨБ, бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах болон бусад ажилтны мэргэжлийн хөгжлийг тасралтгүй, тогтвортой дэмжих
- Боловсролын хөгжлийн бодлого, стратегийг таниулах, хэрэгжилтэнд нь дэмжлэг үзүүлэх
- Багшийн хөгжлийг дэмжсэн сургалтын цахим орчин бүрдүүлэх
- Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох гэх мэт багшийн хөгжлийг дэмжсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах
- Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль /1999.05.14/
- Архивын тухай хууль /2015.12.04/
- Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн эрх үүрэг, үйл ажиллагааны цар хүрээг тодорхой болгосон “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль шинээр батлагдаж 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөхөөр болсонтой холбоотойгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/482 тоот тушаалаар бүтэц орон тоо нь шинэчлэгдсэн байна.
- Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны Эрх олгох зөвлөлийн 2018 оны 01 тоот тогтоолоор 1 дэх жилдээ ажиллаж буй багшийн шалгалтын хураамжийг чөлөөлсөнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагаанаас олох орлогын төлөвлөгөө 10.9 хувьтай биелсэн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "ACOLOUS" програм хангамж ашигладаг байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад удирдлагын зүгээс тавьж буй дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, аудитын эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллага нь төсвөөс санхүүждэг тул нийт зардлыг нарийвчлан хянаж, эрсдэлтэй асуудлыг тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны нийт зардал 2,740,236.6 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 27,402.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд тус байгууллагын мэдээ, мэдээлэлтэй танилцсаны үндсэн дээр материаллагын хувийг сонгосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад нийт 1,015,021.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангаарх цэвэр мөнгөн гүйлгээний дүн 237.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 964,967.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.
- Удирдах дээд байгууллагын тушаал шийдвэргүйгээр 35,704.8 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг данснаас хасаж бүртгэсэн.
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжийн орлогыг 2,006.7 мянган төгрөгийн буцаасан орлогын дүнгээр илүү тайлагнасан
- Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны Эрх олгох зөвлөлийн 2018 оны 1 дүгээр тогтоолын дагуу төлбөргүй болсон үйлчилгээний орлогын 12,105.5 мянган төгрөгийн буцаалтыг туслах үйл ажиллагааны орлого болон бараа ажил үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	209,651.8	
2	Албан шаардлага өгсөн	1	54,011.9	
	Дүн	4	263,663.7	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1. Балансын данстай холбоотой асуудал

Нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг илүү шилжүүлснээс 40,883.5 мянган төгрөгийн авлага, хувь хүний орлогын албан татварын өглөг болон нэр данс зөрүүтэйгээс буцаж орж ирсэн төлбөрийг тайлант хугацаанд шилжүүлээгүйгээс 13,128.4 мянган төгрөг, нийт 54,011.9 мянган төгрөгийн авлага, өглөг үүсгэсэн.

Энэ нь аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдийг хангаагүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх" зарчим, 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хэвлэмэл материалын худалдан авалтанд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхийг магадлах.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөрт арга хэмжээнд зориулан 2018 онд 1,070,136.5 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 273,914.0 мянган төгрөг, нийт 1,344,050.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, улсын төсвийн биелэлт 100%, өөрийн үйл ажиллагааны биелэлт 10,8 хувьтай байгаа нь боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны Эрх олгох зөвлөлийн 2018 оны 01 тоот тогтоолоор 1 дэх жилдээ ажиллаж буй багшийн шалгалтын хураамжийг чөлөөлсөнтэй холбоотой байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 81 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг хэмнэж ажилласнаас шалтгаалсан.

Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 1,273,566.0 мянган төгрөг, төрийн болон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 122,730.0 мянган төгрөг мөн өөрийн үйл ажиллагаанаас 3,437.5 мянган төгрөг орлого орж ирснээс нийт 1,375,920.2 мянган төгрөг зарцуулагджээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны мэдээлэлд 113 мэдээлэл оруулах байснаас 76-г оруулж 37 мэдээлэл оруулаагүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн. Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Татварын тооцоолол, тайлагнал

3.1.1 Илрүүлэлт:

Ажиллагсдын цалингаас суутгах Хувь хүний орлогын албан татварыг 334.6 мянган төгрөгөөр дутуу суутгасан байна. Энэ нь “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээг баримтлаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүд зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг мөрдөж, татварын хөнгөлөлтийн тооцоог үнэн зөв хийх

3.2 Санхүүгийн тайлагнал

3.2.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаарх төлөх дүн цахим хаяг дахь тайлагнасан дүнгээс 534.2 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдэлтэй

нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүд зөрчигдөх
- Өглөг авлага буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж

- Тооцсон цалингийн мэдээллийг нийгмийн даатгалын цахим системд бүрэн оруулж байх

3.3 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.3.1 Илрүүлэлт:

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь сургалтын гарын авлага, үнэмлэх батламж, хоол зэрэг 208,783.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд худалдан авалтаар бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-г "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн.

3.3.2 Эрсдэл:

- Энэ нь “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүд зөрчигдөх,
- Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	92,991,029.16	122,804,479.50
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	29,599.10	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	29,599.10	-
31110	Төгрөг	29,599.10	-
33	АВЛАГА	114,785.06	40,983,555.10
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	55,474.00	-
335	Бусад авлага	59,311.06	40,983,555.10
3351	Байгууллагаас авах авлага	59,311.06	40,983,555.10
35	БАРАА МАТЕРИАЛ	92,846,645.00	81,820,924.40
351	Түүхий эд материал	17,294,590.00	17,294,590.00
35110	Тусгай зориулалттай материал	17,294,590.00	17,294,590.00
354	Хангамжийн материал	75,552,055.00	64,526,334.40
35410	Бичиг хэргийн материал	37,633,187.00	33,330,050.00
35420	Аж ахуйн материал	37,587,968.00	29,766,284.40
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,430,000.00
35440	Түлш шатах тослох материал	330,900.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,682,179,204.47	6,386,463,913.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,682,179,204.47	6,386,463,913.08
392	Биет хөрөнгө	5,681,065,644.47	6,386,304,833.08
39201	Барилга, байгууламж	6,168,507,600.00	6,195,347,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-783,914,507.50	-
39203	Авто тээврийн хэрэгсэл	173,811,653.00	173,811,653.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	125,585,106.87	147,155,106.87
39205	Машин, тоног төхөөрөмж	421,396,092.36	421,396,092.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-307,298,105.05	-366,923,139.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,201,022.20	243,201,022.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-109,179,993.67	-133,500,095.95
39217	Номын фонд	126,990.00	126,990.00
393	Биет бус хөрөнгө	1,113,560.00	159,080.00
39301	Програм хангамж	8,762,400.00	8,762,400.00
39302	Хасагдуулга	-7,648,840.00	-8,603,320.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,775,170,233.63	6,509,268,392.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	52,919.21	13,723,766.38
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	52,919.21	13,723,766.38
413	Өглөг	52,919.21	10,265,399.38
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	52,919.21	10,265,399.38
4136	Бусад өглөг	-	3,458,367.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,361,541.00
41362	Хувь хүмүст төлөх өглөг	-	96,826.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,775,117,314.42	6,495,544,626.20
51	Засгийн газрын хувь оролцоо	5,775,117,314.42	6,495,544,626.20
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	6,615,693,446.20	6,615,693,446.20
51101	Өмч: -Төрийн өмч	6,615,693,446.20	6,615,693,446.20
512	Хуримтлагдсан үр дүн	-840,576,131.78	-1,085,115,835.50
51210	Өмнөх үеийн үр дүн	-840,576,131.78	840,576,131.78
51220	Тайлант үеийн үр дүн	-	-244,539,703.72

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	964,967,015.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,775,170,233.63	6,509,268,392.58

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,831,471,325.43	2,495,696,894.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	274,378,000.00	29,309,420.00
120	Нийтлэг татварын бус орлого	274,378,000.00	29,309,420.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	274,378,000.00	29,258,920.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	269,158,000.00	21,277,720.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,220,000.00	7,981,200.00
120009	Бусад орлого	0.00	50,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,557,093,325.43	2,466,387,474.67
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	805,399,466.55	1,070,136,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	805,399,466.55	1,070,136,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,751,693,858.88	1,396,250,974.67
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	476,540,494.88	122,729,974.67
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	1,203,591,090.00	1,273,521,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71,562,274.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,115,579,679.31	2,740,236,598.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,115,579,679.31	2,740,236,598.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,094,579,679.31	2,682,159,015.06
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	883,569,597.38	776,485,697.58
210101	Цалин	667,048,469.49	729,973,797.58
210102	Нэмэгдэл цалин	85,628,999.89	13,711,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	83,442,728.00	32,800,000.00
210104	Урамшуулал	21,639,600.00	0.00
210105	Гэрээтийн цалин	25,809,800.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,004,837.07	77,951,857.61
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	98,004,837.07	66,607,088.61
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	0.00	2,836,192.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	0.00	2,268,954.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	0.00	567,238.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	0.00	5,672,385.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,392,650.52	150,802,501.89
210301	Гэрэл цахилгааны зардал	96,615,549.00	116,119,992.00
210302	Түлш, халаалтын зардал	27,618,268.00	27,231,367.00
210303	Цэвэр, бохир усны зардал	7,158,833.52	7,451,142.89
2104	Хангамж, бараа материалын зардал	50,743,093.23	155,335,742.67
210401	Бичиг хэргийн материал	17,476,302.00	119,517,601.10
210402	Тээвэр, шатахууны зардал	8,776,000.00	8,770,500.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	13,391,358.93	9,897,612.97
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	2,257,644.00	2,202,984.00

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	8,841,788.30	14,947,044.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,336,770.00	7,619,831.00
210604	Урсгал засвар	12,336,770.00	7,619,831.00
2107	Томилолт, зочны зардал	670,829,063.00	368,350,250.00
210702	Дотоод томилолтын зардал	670,829,063.00	368,350,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	144,216,138.10	121,152,214.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	137,625,487.00	116,789,214.61
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,730,000.00	4,000,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	3,860,651.10	363,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,103,487,530.01	1,024,460,919.70
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	806,641,968.12	763,778,612.81
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	296,845,561.89	260,682,306.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,000,000.00	58,077,583.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,000,000.00	26,454,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	26,454,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	21,000,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	31,623,183.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	31,623,183.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-284,108,353.88	-244,539,703.72
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	-284,108,353.88	-244,539,703.72

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,871,693,381.68	2,499,576,932.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	166,799,210.00	33,144,458.00
120	Нийтлэг татварын бус орлого	166,799,210.00	33,144,458.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	166,799,210.00	33,093,958.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	165,809,210.00	21,232,720.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	990,000.00	11,861,238.00
120009	Бусад орлого	0.00	50,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,704,894,171.68	2,466,432,474.67
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	434,836,000.00	1,070,136,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	434,836,000.00	1,070,136,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,270,058,171.68	1,396,295,974.67
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	160,784,171.68	122,729,974.67
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	1,092,485,090.00	1,273,521,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,788,910.00	45,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,482,936,977.02	2,499,606,531.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,482,936,977.02	2,499,606,531.77
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,482,936,977.02	2,441,528,948.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	452,696,371.79	813,913,959.91
210101	Үндсэн цалин	320,889,100.00	733,354,613.91
210102	Нэмэгдэл	66,514,971.79	20,163,546.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,387,500.00	60,395,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,904,800.00	0.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	44,944,895.14	74,235,570.41
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	44,944,895.14	49,185,356.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	0.00	25,050,214.41
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	63,670,399.52	150,802,501.89
210301	Гэрэл цахилгааны зардал	41,348,975.00	116,119,992.00
210302	Түлш, халаалтын зардал	19,380,417.00	27,231,367.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,941,007.52	7,451,142.89
2104	Хангамж, бараа материалын зардал	14,948,715.71	68,229,214.07
210401	Бичиг хэрэг	1,790,660.00	41,284,463.10
210402	Тээвэр, шатахуун	3,639,000.00	6,243,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,063,187.71	9,957,612.97

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	810,000.00	2,202,984.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,645,868.00	8,541,154.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,901,830.00	5,457,800.00
210604	Урсгал засвар	5,901,830.00	5,457,800.00
2107	Томилолт, зочны зардал	499,752,184.00	368,623,850.00
210702	Дотоод албан томилолт	499,752,184.00	368,623,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,360,855.90	125,433,414.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	62,913,404.80	117,658,414.61
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,730,000.00	4,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,717,451.10	3,775,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,661,724.96	834,832,637.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	333,661,724.96	834,832,637.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	58,077,583.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	26,454,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	26,454,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	31,623,183.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	31,623,183.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	388,756,404.66	-29,599.10
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	388,756,404.66	-29,599.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		29,599.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,599.10	0.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан тайлан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
1	2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	6,615,693,446.20	0.00	-556,467,777.90	6,059,225,668.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,615,693,446.20	0.00	-556,467,777.90	6,059,225,668.30
4	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	208,698,500.52	208,698,500.52
8	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,615,693,446.20	0.00	-840,576,131.78	5,775,117,314.42
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,615,693,446.20	0.00	-840,576,131.78	5,775,117,314.42
11	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	964,967,015.50	0.00	964,967,015.50
12	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	-244,539,703.72	-244,539,703.72
16	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	-1,085,115,835.50	6,495,544,626.20

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	29,599.10		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,343,050,500.00	1,092,063,178.57	250,987,321.43	81%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,343,050,500.00	1,092,063,178.57	250,987,321.43	81%
210	Бараа, үйлчилгээний зардал	1,316,596,100.00	1,065,608,778.57	250,987,321.43	81%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	657,363,900.00	657,358,892.00	5,008.00	100%
210101	Үндсэн цалин	587,095,200.00	576,799,546.00	10,295,654.00	98%
210102	Нэмэгдэл	10,660,900.00	20,163,546.00	-9,502,646.00	189%
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	59,607,800.00	60,395,800.00	-788,000.00	101%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,883,600.00	64,986,200.00	13,897,400.00	82%
210201	Тэтгэврийн даатгал	52,589,100.00	40,000,400.00	12,588,700.00	76%
210202	Тэтгэмжийн даатгал	26,358,914.41	24,985,800.00	1,373,114.41	95%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,802,500.00	150,802,501.89	9,999,998.11	94%
210301	Гэрэл цахилгаан	120,038,300.00	116,119,992.00	3,918,308.00	97%
210302	Түлш, халаалт	35,180,600.00	27,231,367.00	7,949,233.00	77%
210303	Цэвэр, бохир ус	5,583,600.00	7,451,142.89	-1,867,542.89	133%
2104	Хангамж, бараа материалын зардал	31,589,400.00	31,601,170.07	-11,770.07	100%
210401	Бичиг хэрэг	9,163,100.00	5,454,419.10	3,708,680.90	60%
210402	Тээвэр (шатахуун)	2,989,700.00	5,445,000.00	-2,455,300.00	182%
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	15,367,500.00	9,957,612.97	5,409,887.03	65%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,463,900.00	2,202,984.00	260,916.00	89%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,605,200.00	8,541,154.00	-6,935,954.00	532%
2106	Эд хогшил худалдан авах	5,760,500.00	5,457,800.00	302,700.00	95%
210604	Урсгал засвар	5,760,500.00	5,457,800.00	302,700.00	95%
2107	Томилолт, зочны зардал	9,686,200.00	3,677,000.00	6,009,200.00	38%
210702	Дотоод албан томилолт	9,686,200.00	3,677,000.00	6,009,200.00	38%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	346,317,700.00	125,433,414.61	220,884,285.39	36%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	335,477,200.00	117,658,414.61	217,818,785.39	35%
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	6,930,000.00	4,000,000.00	2,930,000.00	58%
210806	Мэдээллийн технологийн зардал	3,910,500.00	3,775,000.00	135,500.00	97%
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	26,192,300.00	26,291,800.00	-99,500.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,192,300.00	26,291,800.00	-99,500.00	100%
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,454,400.00	26,454,400.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,454,400.00	26,454,400.00	-	100%

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,454,400.00	26,454,400.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,344,050,500.00	1,099,825,917.00	244,224,583.00	82%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,070,136,500.00	1,070,136,500.00	-	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,070,136,500.00	1,070,136,500.00	-	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	273,914,000.00	29,656,417.00	244,257,583.00	11%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	161,885,000.00	21,232,720.00	140,652,280.00	13%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112,029,000.00	8,423,697.00	103,605,303.00	8%
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	33,000.00		
140020	Бусад орлого	-	33,000.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	101.00	101.00		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	55.00	55.00		
620003	Үйлчлэх ажилтан	45.00	45.00		

4.6 Аудит хийсэн төсвийн тодруулгын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,375,920,169.87
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,375,920,169.87
210	Бараа, үйлчилгээний зардал	1,375,920,169.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,555,067.91
210101	Үндсэн цалин	156,555,067.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,249,370.41
210201	Тэтгэврийн даатгал	9,184,956.00
210202	Тэтгэмжийн даатгал	64,414.41
2104	Хангамж, бараа материалын зардал	36,628,044.00
210401	Бичиг хэрэг	35,830,044.00
210402	Тээвэр (шатахуун)	798,000.00
2107	Томилолт, зочны зардал	364,946,850.00
210702	Дотоод албан томилолт	364,946,850.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	808,540,837.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	808,540,837.55
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,455,041.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,437,541.00
140020	Бусад орлого	17,500.00
1311	Нэмэлт сахнүүжилтийн орлого	1,396,295,974.67
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	122,729,974.67
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,273,566,000.00

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд	Аудитын код:
2019.02.23			САГ-2019/377/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Ажиллагсадын цалингаас суутгах Хувь хүний 334.6 мянган төгрөгөөр илүү хөнгөлж, татварыг дутуу суутгасан байна. .	334.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Бадам
2	НДШ-ийн тайлангаарх төлөх дүн цахим хаяг дахь тайлагнасан дүнгээс 534.2 мянган төгрөгөөр илүү байна.	534.2	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Бадам
3	БМДИ нь 208,783.0 мянган төгрөгийн сургалтын гарын авлага, үнэмлэх батламж, хоол зэрэг бараа материалын худалдан авалтыг шууд худалдан авалтаар хийсэн.	208,783.0	Зөвлөмж өгөх	БМДИ-ийн захирал Ерөнхий нягтлан бодогч Хуулийн зөвлөх	Д.Сүрэнчимэг С.Бадам О.Цоморлиг
4	Нийгмийн даатгалын шимтгэлийг төлбөрийг илүү шилжүүлсэнээс 40,883.5 мянган төгрөгийн авлага, хувь хүний орлогын албан татварын өглөг болон нэр данс зөрүүтэйгээс буцаж орж ирсэн төлбөрийг тайлант хугацаанд шилжүүлээгүйгээс 13,128.4 мянган төгрөг, нийт 54,011.9 мянган төгрөгийн авлага, өглөг үүсгэсэн.	54,011.9	Албан шаардлага хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	С.Бадам
	Дүн	263,663.7			